



БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК  
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСЭЙХАН

2020 оны 02 дүгээр сарын 21 өдөр

### ҮЙЛДВЭРҮҮДИЙН ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ 2020-2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр

Багануур дүүрэг

№	Менежментийн үйл ажиллагаа	Хугацаа /улирал/	Хэрэгжүүлэгч	Үр дүн
1	Паркийн төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр өгсөн зөвлөмж чиглэлийг баримтлан 2017 онд батлагдсан Паркийн хог хаягдлын менежментийг шинэчлэн боловсруулж мөрдөх	2020-2021 IV улирлаас	ҮТА-ны Ахлах мэргэжилтэн Д. Алтангэрэл ҮТ-ийн кластер инженер Э. Энхзаяа	Хог хаягдлын менежмент, төлөвлөгөө шинэчлэгдэж парк, түүний нэгжүүд мөрдөнө.
2	Паркийн үйлдвэрүүдээс гарах хог хаягдлын судалгаа хийж, зайлуулах аргачлалыг БОННУ-ний дагуу шинэчилж мөрдөх	2020-2021 III улирлаас	ҮТА-ны Ахлах мэргэжилтэн Д. Алтангэрэл ҮТ-ийн кластер инженер Э. Энхзаяа	Үйлдвэрүүдийн хуурай, шингэн хорт хаягдлыг тээвэрлэх журам боловсруулагдана.
3	БОАЖЯ-ны БОУ-ний мэргэжлийн зөвлөлөөр байгаль орчны үнэлгээ хийлгэсэн үйлдвэрийн төслийг хүлээн авах журам хэрэгжүүлэх /Төсөлтэй урьдчилан танилцахдаа хог хаягдлын менежментийг тусгах шаардлага тавина/	2020-2021 IV улирлаас	ҮТА-ны Ахлах мэргэжилтэн Д. Алтангэрэл ЗА-ны Ахлах мэргэжилтэн Б. Номинзул	Нэгжээр орох шалгуур үзүүлэлтэд уг асуудлыг тусгасан байна.
4	"Багануур тохижилт" ОНӨААТҮГ-тай хамтын ажиллагааны хүрээнд мод усалгааны худгийн систем болон хог хаягдлын цэгийг боловсронгуй болгох санаачлагыг дэмжиж шинэ аргачлалын санал боловсруулж хүргэх	2020 I ул.	ҮТА-ны Ахлах мэргэжилтэн Д. Алтангэрэл ХЕТ, дэд бүтцийн инженер Б. Мөнгөнхуяг	Газрын даргатай уулзаж санал солилцоно.
5	Багануур дүүргийг "Эко хот" болгон хөгжүүлэх арга хэмжээний талаарх саналыг хэрэгжүүлэх ажлыг үргэлжлүүлэх: 1. "Эко хот" төслийг боловсруулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэх 2. Хог хаяглаар бордоо хийх ажлыг эрчимжүүлэх үүднээс дүүргийн ЗД-ын захирамжийн төслийг боловсруулах	2020-2021 II улирлаас	ҮТА-ны Ахлах мэргэжилтэн Д. Алтангэрэл ЗА-ны Ахлах мэргэжилтэн Б. Номинзул	1. Төслийг боловсруулах санхүүжилтийг Дүүргийн ЗДТГ-т тавина. 2. Захирамжийн төслийг дүүргийн ЗДТГ-т хүргүүлнэ.



6	Дүүргийн нийт ААНБ, хороод, айл өрхийн хэмжээнд үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлаар бордоо хийх танхимын болон үзүүлэх сургалтыг дүүргийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулах	2020 III улирлаас	ҮТА, ЗА-ны инженер мэргэжилтнүүд	Сургалтад нийт 120 гаруй албан хаагч, иргэд хамрагдаж, 40 айл өрхөд үзүүлэх сургалт явуулна.
7	Дүүргийн хэмжээнд үйлдвэрийн болон ахуйн хог хаягдлыг боловсруулан ашиглах үндсэн чиглэлд судалгаа явуулж, нэмэлт өөрчлөлт оруулах	2020 IV улирлаас	ҮТА-ны Ахлах мэргэжилтэн Д. Алтангэрэл ҮТ-ийн кластер инженер Э.Энхзаяа	Хог хаягдлыг дахин боловсруулж түүхий эд, бүтээгдэхүүн гаргах чиглэл, арга ажиллагааны талаарх судалгааг үргэлжлүүлнэ.
8	Дүүрэгт байгуулах хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн талаар мэдээлэл хайх, боломжит хувилбарыг сонгох ажлыг үргэлжлүүлэх	2020 IV улирлаас	ҮТА-ны Ахлах мэргэжилтэн Д. Алтангэрэл ҮТ-ийн кластер инженер Э.Энхзаяа	Хаягдал боловсруулах үйлдвэрүүдийн талаар мэдээлэлтэй болж, байгуулахад тохиромжтой хувилбар сонгосон байна.
9	Хаягдлыг ашиглан төрөл бүрийн хэрэгцээт зүйл хийдэг өөрийн болон гадаад орны туршлагын мэдээлэл цуглуулж, сурталчлах ажлыг ЖДҮДТ-тэй хамтран зохион байгуулах	2020-2021 III улирлаас	ҮТА-ны Ахлах мэргэжилтэн Д. Алтангэрэл ХЕТ, дэд бүтцийн инженер Б. Мөнгөнхуяг	Мэдээлэл сурталчилгааны олон талт ажлыг зохион байгуулна.
10	Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах үйл ажиллагаа явуулж байгаа гадны үйлдвэрүүдтэй танилцах, бүтээлч аялалыг ЗДТГ-тай хамтран ААНБ-уудын төлөөллийг оролцуулж зохион байгуулах	2020-2021 III улирлаас	ЗА-ны Ахлах мэргэжилтэн Б. Номинзул	УБ хотын хог хаягдлыг боловсруулах үйлдвэрүүдтэй танилцах аялалыг зохион байгуулна.

**Жич :**

1. Томоохон ажлуудыг жич төлөвлөгөө гаргаж зохион байгуулна.
2. Төлөвлөгөөний биелэлтийг жил бүрийн эцэст гаргаж дүгнэнэ.

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:  
ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН АЛБАНЫ  
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН



Д. АЛТАНГЭРЭЛ

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН  
КЛАСТЕР ИНЖЕНЕР



Э. ЭНХЗАЯА